
Монгол Улсын Үндэсний аудитын газар

ҮАГ

УИХ-ын Нийгмийн бодлогын Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2005 оны 4 дүгээр
сар

**МУЗЕЙН ҮЗМЭР, ЭД ӨЛГИЙН БҮРТГЭЛ,
БАЯЖУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

**Үндэсний түүхийн музейн 2004 оны үйл
ажиллагааны үр дүн**

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
<hr/>		
Аудитын дүн	Музейн сан хөмрөгийн баталгаат бүртгэл, бүртгэл мэдээллийн сан, бүртгэл лавлагааны материалын бүрдүүлэлт	5-7
	Музейн сан хөмрөгийн баяжуулалт, хадгалалтын нөхцөл	8-9
	Музейн үзмэр, сан хөмрөгийн харуул хамгаалалт, дотоод хяналт	9
	Музейн барилга, үзмэрийн талбайн ашиглалт, зохион байгуулалт	9-10
	Төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт	10-13
	Хандив тусламжаар нийлүүлэгдсэн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт	13
	Төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт	13-14
	<hr/>	
Дүгнэлт		15-16
Холбогдох байгууллагын санал	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	17
	Үндэсний түүхийн музей	18
<hr/>		
Зөвлөмж		19-20
Хавсралтууд	Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт, нотолгооны баримт слайд зураг	21

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний түүхийн музейн үйл ажиллагаанд аудит хийлээ.

Аудитыг Үндэсний аудитын газрын 2 дугаар хэлтсийн шинжээч Ц.Сугармаа 2005 оны 1 дүгээр сарын 26-наас 4 дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитад Үндэсний түүхийн музей, түүний харъяа Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын музейг хамрууллаа.

Аудитын зорилт нь дараахь асуудлыг шалгаж, дүгнэлт зөвлөмж гаргахад чиглэгдсэн болно. Үүнд:

- Музейн сан хөмрөгийн баталгаат бүртгэл, бүртгэл мэдээллийн сан, бүртгэл лавлагааны материалын бүрдүүлэлт
- Музейн сан хөмрөгийн баяжуулалт, хадгалалтын нөхцөл
- Музейн үзмэр, сан хөмрөгийн харуул хамгаалалт, дотоод хяналт
- Музейн барилга, үзмэрийн талбайн ашиглалт, зохион байгуулалт
- Төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт
- Хандив тусламжаар нийлүүлэгдсэн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт
- Төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт

Аудит хийхдээ ҮТМузейн санхүүгийн болон бусад баримт материал, холбогдох байгууллагаас авсан мэдээ судалгаанд үндэслэн түүвэрлэн шалгах болон шинжилгээний арга зүй, горимыг ашиглав.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур

Үндэсний түүхийн музейн үйл ажиллагаанд хийсэн аудитад дараахь эрхийн актыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Соёлын сайдын 1995 оны 6 дугаар тушаалаар баталсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”
- Гэгээрлийн сайдын 1997 оны 330 дугаар тушаалаар баталсан “Улс, аймгийн чанартай музейн дүрэм”
- Гэгээрлийн сайдын 1999 оны 49 дүгээр тушаалаар баталсан “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар”
- Холбогдох бусад хууль, эрхийн актууд болон байгууллагын мөрдөж буй дүрэм, журам, тушаал шийдвэрүүд

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Энэхүү аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын дүн

1.Музейн сан хөмрөгийн баталгаат бүртгэл, бүртгэл мэдээлийн сан, бүртгэл лавлагааны материалын бүрдүүлэлт

Тус музейн бүртгэл мэдээлийн сан нь:

- Данс бүртгэл
- Байршлын карт
- Үзмэрийн гэрэл зурагжуулалт
- Эрдэм шинжилгээний тодорхойлолт
- Судалгаа шинжилгээний тайлан зэргээс бүрддэг байна.

Данс бүртгэлийн талаар

Музейд байгаа сан хөмрөгийн 17013 дугаар бүхий 19 дансанд 48679 нэгж буюу 382076,8 мянган төгрөгийн үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэжээ. Сан хөмрөгийг дотор нь түүх, угсаатны гэж ангилан тус бүрийг хариуцсан сан хөмрөгийн эрхлэгчид ажиллаж бүртгэлийг үндсэн, солилцооны, эрдэм шинжилгээний туслах, гэрэл зургийн гэж ангилан орон тооны тоо бүртгэгч хариуцан хяналт тавин ажиллаж байна.

Байршлын картын талаар

Биет үзмэр, гэрэл зургийн картууд нь музейн мэдээлэл лавлагааны катологийг бүрдүүлдэг. Нийт 17013 данс бүхий үзмэрийн 10894 үзмэрт карт хийгдсэн нь 64 хувийг эзэлж байна.

Үзмэрийн гэрэл зурагжуулалтын талаар

Дансны дугаар бүхий 17013 үзмэрийн 5493 үзмэрт буюу 32 хувьд нь гэрэл зурагжуулалт хийгджээ. Эдгээр зургийг өнгөтөөр авч сэдэвчилэн цомог /альбом / болгосон байна. 2000 оноос эхлэн үзмэрийн гэрэл зургийг компьютерт оруулж эхэлсэн бөгөөд 2004 оны байдлаар 1027 гэрэл зураг компьютерт хийгдсэн байна.Мөн компьютерээр түүхэн гэрэл зургийг сэргээн засварлах ажил хийж, одоогийн байдлаар 1200 гэрэл зургийг сэргээн засварлажээ.

Эрдэм шинжилгээний тодорхойлолт

Бүртгэл мэдээлийн санд Хувьсгалын музей байх үеэс эхлээд хар зураг бүхий эрдэм шинжилгээний паспорт, эрдэм шинжилгээний тодорхойлолтын боть, одоо хийгдэж байгаа өнгөт гэрэл зурагтай түүх, соёлын дурсгалт зүйлийн тодорхойлолтууд байна. Эрдэм шинжилгээний тодорхойлолтыг нийт үзмэрийн хэмжээнд авч үзвэл 7260 үзмэрт буюу 43 хувьд нь тодорхойлолт хийгдэж бусад нь тодорхойлолтгүй байна.

Судалгаа шинжилгээний тайлан

Дээр дурдсан бүртгэл мэдээллийн сангийн баримт бичгээс гадна судалгаа, шинжилгээ, мэдээлэл-лавлагаа, сурталчилгааны бусад материалыг бүрдүүлдэг. Үүнд гадаад, дотоод нүүдлийн үзэсгэлэн,

Аудитын дүн

хээрийн шинжилгээний хэвлэгдсэн болон хэвлэгдээгүй тайлан 18, гадаадад гаргасан 6 үзэсгэлэнгийн католог ном, бусад музейтэй хамтарсан үзэсгэлэнгийн 6 католог, бусад байгууллагатай хамтарч зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын хэвлэгдсэн илтгэл ном зэргийг гаргажээ.

Гэвч 17013 дугаар бүхий 48679 нэгж үзмэрийн 40-50 хувьд хийгдсэн гэрэл зураг бүдэг, үзмэрийг тал бүрээс нь аваагүй, ерөнхий авсан, үзмэрийн мэдээлэл лавлагааны карт, эрдэм шинжилгээний тодорхойлолт хийгдсэн байдал нь Музейн дүрэм, Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх журамд заасан шаардлагыг хангаагүй байна.

Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийн тооллого явуулах журам”-ыг үндэслэн Гэгээрлийн сайдын 1998 оны 277 дугаар тушаал гарч музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах ажлын хэсэг томилогдож тооллого явуулсан боловч дүн нь одоо болтол гараагүй байна. Тооллогоор данс бүртгэлд байхгүй үзмэр эд өлгийн зүйлс нилээд илэрч, энэ хугацаанд эд хөрөнгө хариуцаж байсан таван сан хөмрөгч солигдсон, сан хөмрөгч солигдоход үзмэр эд өлгийн зүйлийг хүлээлцсэн акт алга байгаа нь ноцтой асуудал юм.

Энэ нь өмч хөрөнгө, музейн үнэт эдлэл солигдох, алга болох нөхцөл бүрдсэнийг харуулж байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын тооллогыг 4 жил тутам соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах, тооллого явуулах журмыг Засгийн газар тогтоохоор заасны дагуу түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын тооллогыг цаг алдалгүй явуулж, улсын онцгой объектод хадгалагдаж байгаа үзмэр, эд өлгийн бүртгэл, сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын өнөөгийн байдлыг дүгнэх зайлшгүй шаардлага байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу түүх, соёлын дурсгалт болон оюуны соёлын үнэт зүйлийн тодорхойлолт, судалгаа шинжилгээний ажлын тайлан, гэрэл зураг, слайд, дуу болон дүрс бичлэгтэй хальс, цахим зээрэнцэг, сэргээн засварлах ажлын товч тайлан зэргийг Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэх ажил хангалтгүй хийгдэж байна. Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд одоогийн байдлаар Улсын 6 музей, орон нутгийн музейнүүд, шашин сүм хийдийн

Аудитын дүн

газраас дөнгөж 5025 нэгж үзмэр бүртгэгдсэн байгаагийн дотроос тус музейн 42 нэгж үзмэрийг бүртгэсэн байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.1-д Түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлоор нь **хосгүй үнэт, үнэт, ердийн гэж** зэрэглэнэ, мөн хуулийн 5.2-д түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөл тодорхойлно гэж заасан.

Үүний дагуу БСШУ-ны сайдын 2002 оны 75 дугаар тушаалаар 9 гишүүдийн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн зөвлөл байгуулагдан ажиллаж байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.6-д зааснаар Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд нийт 228 ширхэг түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэсэн боловч мэргэжлийн зөвлөл нь хосгүй үнэт зүйлсийн гэрчилгээг олгоогүй өдийг хүрсэн байна.

Зөвлөлийн оруулсан саналыг үндэслэн Засгийн газрын 2004 оны 108 дугаар тогтоолоор “Хосгүй үнэт” зүйлсэд оруулах түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтыг баталжээ. Энэхүү жагсаалтад бүртгэгдсэн ҮТМ-д байх ёстой **“Богд хаант монгол улсын төрийн далбаа”** тус музейд биетээр байхгүй, хаана байгаа нь тодорхойгүй байна. Энэхүү Богд хаант монгол улсын төрийн далбааг олж, музейд нь шилжүүлэх албан шаардлагыг БСШУ-ны яаманд өглөө.

Музейн үзмэр, эд өлгийн зүйлд үнэ тогтоох үнэлэх асуудал хангалтгүй, үзмэр, эд өлгийн зүйлийн дахин үнэлгээ улсын хэмжээнд хийгдээгүй байна.

БСШУ-ны яамнаас тооллого явуулах аргачлал, заавар гаргаагүй, мэргэжлийн зөвлөлөөс түүх, соёлын дурсгалт зүйлийг мэргэжлийн түвшинд үнэлж, тодорхойлох асуудал дутмаг, дотоод журмын дагуу хийх ажлаа бүрэн хийгээгүй, албан ёсны шийдвэр гаргаж ажлаа дүгнэдэггүй, музейн мэргэжлийн боловсон хүчин ажилладаггүй, мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангаж ажиллаагүй зэрэг дутагдал байлаа.

Иймд БСШУЯ музейн мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үзмэр, эд өлгийн зүйлийг үнэлэх үнэлгээний итгэлцүүр аргачлал, заавар, гаргаж харьяа музейнүүдэд мөрдүүлэх нь зүйтэй юм.

Аудитын дүн

2. Музейн сан хөмрөгийн баяжуулалт, хадгалалтын нөхцөл

1.Тус музей нь АНУ–ын Смитсоны хүрээлэнгийн Байгалийн түүхийн музейтэй хамтарсан” Буган чулуу хөшөө” төслийн хүрээнд хайгуул /хээрийн/ шинжилгээний анги зохион байгуулж Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрийн хүрлийн үеийн буган чулуун хөшөө, хиргисүүр болон цаатны судалгааны мэдээ баримт, эд өлгөөр сан хөмрөгөө баяжуулахын зэрэгцээ нүүдлийн соёл иргэншлийг судлах Олон улсын хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Алс дорнодын хүрээлэнтэй хамтарсан хайгуул шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд багтан 2004 онд Булган аймгийн зарим сумдын нутагт ажиллаж үйсэн дээр бичсэн эртний номын хуудсууд, мянган жилийн өмнөх шүдний сойз, чулуун уур, тээрэм, шаазан хүн, чулуун арслан, Хятаны үеийн бичигтэй ваарны хагархай, эртний зоос зэрэг 30 гаруй ховор чухал дурсгалууд илрүүлэн олжээ.

Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө цайдам дахь Билгэ хаан, түүний хатны гантиг цагаан хөшөө, Билгэ хааны тахилын онгоныг малтах явцад олдсон алт мөнгөөр бүтээгдсэн хосгүй үнэт олдвороор музейн үзүүллэгийн Түрэг, Уйгарын танхимийг шинэчлэн дэглэж үзэгчдийн хүртээл болгожээ.

Улсын хил нэвтрэх үед албан ёсны зөвшөөрөлгүй авч гарах оролдлогын улмаас Гаалийн ерөнхий газарт хураагдсан бүгд 30 нэр төрлийн 410 ширхэг эд зүйлийг түүх, соёлын дурсгалт зүйл гэдэг ангиллаар бүртгэн хадгалж байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.5-д заасны дагуу хил гааль дээр хураагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг зохих байгууллагад нь үнэ төлбөргүй шилжүүлэх ёстой боловч хуулийн энэ заалт хэрэгжээгүй байна.

Энэ байдал нь музейн агуулга, төрөл, чиглэлд тохирсон сан хөмрөгийн баяжуулалтын тодорхой төлөвлөгөөгүй, тохиолдлын түүвэр, олдвор цуглуулгаар хязгаарлагдаж байгааг харуулж байна.

Гэгээрлийн сайдын 1999 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Музейн үзмэрийг хадгалж, хамгаалах заавар”-ын дагуу музейн үзмэрийн хадгалалтын нөхцлийг шалгахад:

- Сан хөмрөгийн өрөөнүүд барилгынхаа хонгилд байрладаг учир зуны улиралд хэт өндөр чийгшэлтэй байдаг,цементэн шалтай учир эд өлгийн зүйлийг хадгалах горим алдагдсан,
- Сан хөмрөгийн өрөө дан хаалгатай, дохиололгүй

Аудитын дүн

- нөхцөлд байдаг,
- Хосгүй болон үнэт эдлэлийг тусгаарлан хадгалах зориулалтын шүүгээ байхгүй,
- Сан хөмрөгийн өрөөнүүдэд хийсэн агааржуулагч тоногдож ажиллахгүй болсон,
- Сан хөмрөгийн өрөөнд тогтмол цэвэрлэгээ хийдэггүй учраас үзмэр, эд өлөг агаарын бохирдол ихтэй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

Дулаан чийгшил үздэг аппарат байдаг боловч үүнийг тогтмол ажиллуулж, өдөр бүр бүртгэлийн дэвтрийг хөтөлдөггүй байна. Иймд үзмэр, эд өлгийн хадгалалтын нөхцлийг эрс сайжруулж дээрх зааврыг мөрдөж ажиллах нь зүйтэй байна.

3.Музейн үзмэр, сан хөмрөгийн харуул хамгаалалт, дотоод хяналт

Монгол Улсын Үндсэн хуулийн 7.1-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заажээ. Иймд музей нь улсын онцгой объектод тооцогдож төрийн хамгаалалтад хамаарагддаг. Одоогийн байдлаар музей нь дохиолол хамгаалалтын “Цагаан бар” ХХК-тай харуул хамгаалалтын гэрээтэй ажиллаж байна. Харуул хамгаалалтын үйл ажиллагааг 4 хамгаалагч 24 цаг биечлэн хариуцдаг. Галын аюулгүй байдлыг хангах үүднээс Гамшиг судлалын үндэсний төвийн шинжээчийн заавраар үзмэрийн танхим, сан хөмрөгийн ихэнх цахилгааны утсыг сольж, метал болон хуванцар сувагт далдалж, оруулга, дохиоллын утсыг тусгаарлан багцалж, цахилгааны монтажийг шинэчлэх ажлыг хийжээ. 2001 онд үзмэрийн дохиоллын системийг авч тавьсан боловч ажилладаггүй, музейн захиргааны албан тасалгаанууд, үзмэрийн танхим, үзмэрийн сан хөмрөгийн өрөөнүүдийн цонх бэхэлгээний хаалтууд хагас дутуу хийгдсэн, аюулын суурин болон зайн товчлуур байхгүй, үзүүллэгийн танхим, өрөө тасалгаануудыг холбосон дотуур холбоог тавиулсан боловч ажилгүй болсон байгаа нь тус музейд хадгалагдаж буй нэн ховор, үнэт эдлэл, үнэлэмж өндөртэй үзмэрүүдийн хамгаалалтын шаардлагыг хангаж чадахгүй байна.

4. Музейн барилга, үзмэрийн талбайн ашиглалт, зохион байгуулалт

Музейн байрны 316.8 кв.м талбай буюу 38.3 хувийг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст түрээслүүлжээ. Төрийн өмчийн хорооны 2002 оны 562 дугаар тогтоолоор төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлж болох боловч

Аудитын дүн

Гэгээрлийн сайдын 1997 оны 330 дугаар тушаалаар баталсан “Улс, аймгийн чанартай музейн дүрэм”-ийн 2.9, 2.10, 7.1, 8.1-дэх /Музей нь монгол нутаг дахь хүний амьдралын түүх, соёл, урлаг, ёс заншил, байгаль орчны тухай бодит баримтат материалуудыг цуглуулан хадгалж, судлан шинжлэх, дэглэн үзүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагааг байнга явуулах үүрэг бүхий, ашгийн бус, соёлын байгууллага, музейн зориулалтын байрыг зөвхөн музейн үйл ажиллагаанд ашиглана, үзэгчдэд зориулан музейн байр, танхимын цэвэр тохилог орчин бүрдүүлэх, сан хөмрөгөө түшиглэн үзэсгэлэн зохион байгуулж, үзэсгэлэнгийн байнгын танхим ажиллуулах, музейн байранд өөрийн бэлэг дурсгалын дэлгүүр ажиллуулж болно/ заалтыг зөрчиж, хэт их талбайг түрээсэлж, үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг алдагдуулсан, үзмэр, үзүүлэгийн танхимуудын зай хомс, байнгын үзэсгэлэн гаргадаг танхимд банк байрлуулсан, төрийн бус байгууллага, хувь хүнд өрөөг олноор түрээсэлсэн, эртний эдлэл зардаг дэлгүүр, баар цайны газар ажиллуулснаас хамааран музейн албан хаагчдын ажлын байрны ачаалал, ая тухтай байдлыг алдагдуулахад хүргэсэн байна.

Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 182 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны түр журмын” 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-т /Мөнгөн кассын өрөө нь бусдаас тусгаарлагдсан, цонх, хаалгыг төмөр сараалжаар бэхэлсэн байх бөгөөд мөнгө, үнэт цаасыг шатахгүй төмөр сейфэнд хадгална, мөнгөн кассын өрөөнд кассын шалгалт хийх эрх бүхий хүмүүсээс бусад хүнийг оруулж болохгүй, ажлын зайлшгүй шаардлагаар орох хүмүүсийг байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэгтэй тусгай зөвшөөрлөөр орно/заасныг зөрчиж, үйлчлүүлэгчийн хувцас өлгөдөг өлгүүр, цүнх саваа тавьдаг шүүгээ байрласан өрөөнд билетийн кассыг байрлуулсан зэрэг зөрчил илэрсэн тул арилгуулахаар албан шаардлага өгөв.

5. Төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт

Тус музей төрийн сангийн 3307004 тоот дансаар гүйлгээ хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулах эрхийн нэгдүгээр гарын үсгийг захирал А.Очир, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Наранчимэг нар зурж хөрөнгийг зарцуулжээ.

2004 онд 120.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж 89.3 сая төгрөгийн зардал гаргаж 31.3 сая төгрөгөөр төсвийг

Аудитын дүн

ХЭМНЭЖЭЭ.

ҮТМ-н 2004 оны үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэл

/ мян.төю /

Үзүүлэлт	2004 он		
	Төл	Гүйц	Зөрүү /+,-/
Нийт орлого	96519.5	120640.5	24121.0
Үүнээс: Төсвийн санхүүжилт	38519.5	38519.5	0.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	24000.0	42428.8	18428.8
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	29000.0	34692.2	5692.2
ШУТСангаас	5000.0	5000.0	0.00
Нийт зарлага	96519.5	89275.2	-7244.3
Үүнээс: Цалин	27874.6	27874.6	0.00
Нийгмийн даатгал	7358.9	7358.9	0.00
Бараа, үйлчилгээний зардал	61286.0	54041.7	-7244.3

Нийт орлогын 38.5 сая төгрөг буюу 32 хувийг улсын төсвөөс, 42.4 сая төгрөг буюу 35.1 хувийг музейн үндсэн үйл ажиллагааны орлогоос, 34.6 сая төгрөг буюу 28.7 хувийг түрээсийн орлого болон бусад орлогоос бүрдүүлжээ.

ШУТСангаас “Музейн менежмент, маркетингийг сайжруулах, арга зам” төслийн үлдэгдэл 5.0 сая төгрөгийг авсан байна.

Төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч өөрийн орлогын төлөвлөгөөг 24.0 сая төгрөгөөр буюу 45.2 хувиар давуулан биелүүлжээ. Үүнд: Нийт үзэгчид 2004 онд 49000 гаруй болж үүнээс гадаадын үзэгчид урьд оноос 7000-8000 үзэгчээр нэмэгдсэн, музейг сурталчлах зорилгоор оюутан сурагчдад 4 өдрийн үнэгүй үйлчилгээ зохион байгуулсан, БСШУ-ны сайдын 54 дүгээр тушаалаар урьд нь ялгавартай байсан билетийн үнийг гадаад, дотоодын үзэгчдэд ижилхэн 2500 төгрөг болгож нэмэгдүүлсэн, АНУ-ын ЭСЯ-ны санхүүжилтээр гэр бүлийн тасалбар хэвлүүлэн түүнийг дагалдах маркетингийн иж бүрэн үйлчилгээг бий болгох төслийг хэрэгжүүлсэн байна.

Жуулчдыг татахын тулд аялал жуулчлалын компаниудтай гэрээ хийж захиалгаар тайлбартай үйлчилсэн, үзүүлэгийн танхимын план зураг, нэр хаяг зэрэг үзэгчдэд нэн түрүүн шаардлагатай мэдээллийг агуулсан англи хэлээр хэвлүүлсэн нугалбарыг үнэгүй

Аудитын дүн

түгээж байгаа нь гадаадын үзэгчдийн сэтгэлд нийцсэн, үндэсний хувцасны үзүүлэгийн имижийг шинээр нээн сурталчлах зэрэг ажлыг зохион байгуулснаар үзэгчдийн тоо, орлогыг нэмэгдүүлсэн байна.

Гэвч музей үзэгчид, холбогдох байгууллага, ажилтан ажилчдын ярилцлага, санал бодлыг дүгнэж үзэхэд үзмэрүүдийг тайлбарласан мэдээ товч, үзмэрээ шинэчилдэггүй, монгол тайлбарлагч хүрэлцдэггүй зэрэг гомдол санал гарсаар байна.

Музейн үндсэн үйл ажиллагаа болох үзмэр тойруулан зохион байгуулах олон талт үйл ажиллагаанаас олох орлогын хувь бага байна.

Орлого нэмэгдсэн гол шалтгааныг авч үзвэл: билетийн үнийг нэмэгдүүлсэнээс 19.0 сая төгрөг, музейн үндсэн байрыг түрээслүүлснээс 25.1 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Түрээсийн орлогоор нийт 25190.2 мянган төгрөгийн орлого олж 3601.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5, Төрийн өмчийн хорооны 2001 оны 562 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг зөрчин түрээсийн төлбөрийн шимтгэлийг дутуу шилжүүлжээ. Улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн 1436.8 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасныг үндэслэн акт тогтоов. 2004 онд нийт 89.2 сая төгрөг зарцуулж зардлыг 7.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Цалин шимтгэл, бичиг хэрэг, харуул хамгаалалтын зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулж, үзмэр, эд хөрөнгө худалдан авах зардлыг зарцуулаагүй, халаалтын тоолуур тавьснаар түлш халаалтын зардлыг 6.2 сая төгрөгөөр хэмнэжээ. ШУТСангаас санхүүжүүлж байгаа “Монголын музейн менежмент, маркетингийг сайжруулах арга зам” төсөл 2002-2004 онд дуусах байтал төслийн баримт бичиг бэлэн болоогүй, үр дүн нь гараагүй байна.

6.Хандив тусламжаар нийлүүлэгдсэн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

Тайлант жилд хандив тусламжаар Монгол төвдийн хорооноос пентиум IY маркийн компьютер 5 ширхэг, принтер 1 ширхэг, хувилагч машин 1 ширхэг, бүгд 7097.2 мянган төгрөгийн хөрөнгийг авч бүртгэл тайланд тусгасан байна. Гэвч хандив тусламжаар болон бэлгийн журмаар өгч байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг цаг тухайд нь тушаал шийдвэр гарган үнэлж орлого авч бүртгэл тайланд тусгаагүй, өмч хөрөнгөнд тавих хяналт

Аудитын дүн

сул байна. Тухайлбал:

БСШУ-ны яамны Соёл урлагийн сангаас 8175.0 мянган төгрөг шилжүүлэн Франц улсаас дуудлага худалдаагаар авсан /Монголын цэргийн хуяг, нум, сумын хамт/ үнэт үзмэрийг орлого авч бүртгэл тайланд тусгаагүй, БНСУ-ын музейгээс хандив тусламжаар ирсэн 9696.0 мянган төгрөгийн үзмэрийн хорго, дагалдах тоног хэрэгслэлийн хамт бэлгээр болон шилжүүлгээр авсан 1958.3 мянган төгрөгийн түүх, соёлын дурсгалт зүйлийг үнэлж, орлого авч бүртгэл тайланд тусгаагүй зөрчил илэрлээ. Дээрх хөрөнгийг орлогод авч, бүртгэлд тусгахыг санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжид заасан болно.

7.Төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт

Тайлант жилд 25088.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө, 4500.7 мянган төгрөгөөр эргэлтийн хөрөнгө нэмэгдэж, музей нь 699103.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 15960.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй болжээ. 2004 оны жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн тооллого хийж, тооллогоор олон жил ашиглалтгүй байсан, цаашид хэрэглэгдэхгүй болсон 551.2 мянган төгрөгийн хөрөнгийг актлахаар тогтож, Төрийн өмчийн хороонд санал оруулсан байна.

Музейн үзмэр болон хөрөнгийн байдлыг шалгалтын хугацаанд түүвэрлэн үзэхэд ашиглалтгүй болсон өмч хөрөнгө нэлээд байна. Тухайлбал, 2001 онд гэрээ байгуулан хувь хүнээр Чингис хааны лаан баримал, Эрдэнэ зуугийн макет, Богд хаан, Эх дагина нарын лаан баримлыг 6800.0 мянган төгрөгөөр хийлгэж музейн танхимд тавьсан нь тасалгааны температурт зохицохгүй урсаж өнгө зүс, хэлбэр дүрсээ алдаж, үзмэрийн шаардлага хангахгүй болж, үр ашиггүй зардал гарчээ. Мөн 2001 онд 16818.1 мянган төгрөгөөр авч тавиулсан дохиоллын систем /Камер 8, сенсор 13, бусад тоног төхөөрөмжийн хамт/ 6 сарын хугацаатай ажиллаад ашиглалтгүй болсон нь байгууллагын удирдлагаас түүнийг ажиллуулах талаар санаачлага гаргаж ажиллаагүй, өмч хөрөнгөнд үрэлгэн хандаж, нөөц бололцоогоо үр ашигтай зарцуулах талаар хангалтгүй ажилласныг харуулж байна.

Аудитын дүнгээс үзэхэд өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт сул, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 253 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох

Аудитын дүн

бүртгэлийн бодлого, аргачлал, заавар”- ын хэрэгжилт хангалтгүй байна.

ДУГНЭЛТ

Үндэсний түүхийн музейн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна:

- Музейн үзмэр, сан хөмрөгийн судалгаа, баримтжуулалт, лавлагааны материалын бүрдүүлэлт удаашралтай, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх журамд заасан шаардлагын дагуу музейн үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэлд оруулах ажил хангалтгүй хийгдэж байна.
- Музейн үзмэр, сан хөмрөгийн бүртгэл, хяналт сул байна.
- Музейн үзмэр, эд өлгийн зүйлд үнэ тогтоох үнэлгээний итгэлцүүр, аргачлал, заавар дутагдаж байна.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.5 дахь заалтын дагуу Гаалийн ерөнхий газарт хураагдан хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг зохих байгууллагад шилжүүлэх ажил хийгдээгүй байна.
- Музейн агуулга, төрөл, чиглэлд тохирсон үзмэр сан хөмрөг баяжуулалтын төлөвлөгөөгүй, Гэгээрлийн сайдын 1999 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Музейн үзмэрийг хадгалж, хамгаалах заавар”-ыг мөрдөөгүй байна.
- Музейн үзмэр, сан хөмрөгийн харуул, хамгаалалт хангалтгүй байна.
- Музейн байр, талбайн ашиглалтын талаар Гэгээрлийн сайдын 1997 оны 330 дугаар тушаалаар баталсан “Улс, аймгийн чанартай музейн дүрэм”-ийн 2.9, 2.10, 7.1, 8.1 дэх заалтууд зөрчигдөж байна.

ДУГНЭЛТ

- Гадаадын болон дотоодын байгууллага, хувь хүмүүсээс хандив тусламжаар ирж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлс, тоног төхөөрөмжийг тухай бүр орлогод авч, бүртгэлд тусгахгүй байна.
- Төрийн өмч, музейн үзмэрийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт сул, санхүү бүртгэлийн заавар журмыг мөрдөж ажиллагаагүй байна.

Холбогдох байгууллагын санал

Монгол Улсын Боловсрол,
Соёл, шинжлэх ухааны
яамны санал



Санал өгөх тухай

Танай газраас ирүүлсэн "Үндэсний түүхийн музейн үйл ажиллагаа"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Уг тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.



C. Төмөр-Очир
С. ТӨМӨР-ОЧИР

D:\Ganbaa\Alban bichig\1\A5.doc

001000

Холбогдох байгууллагын санал

Монголын Үндэсний
түүхийн музейн санал



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТҮҮХИЙН МУЗЕЙ

2007 оны
4 сарын 27-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот -01
Утас: 526832

Холбогдох байгууллагын санал

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Шалгалтын дүнгийн тухай

Танай байгууллагаас 2005 оны 1 сарын 26-аас 4 сарын 10-нд манай Үндэсний түүхийн музейн ажилд шалгалт хийж, үрэлгээ дүгнэлт гаргасантай танилцлаа. Төний шинэсэлтийн хийсэн үрэлгээ, дүгнэлт, өгсөн зөвлөгөө нь манай музейн ажлыг сайжруулахад зохих ач холбогдолтой үр дүнтэй ажил боллоо хэмээн үнэлж байна.

Шалгалтын дүнгийн тухай зарим зүйлд хурмын үеэр тайлбар хийх боломжтой байна.



ЗАХИРАЛ: ПРОФЕССОР

A. O. Chir
А.ОЧИР

Зөвлөмж

Үндэсний түүхийн музейн 2004 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтийг үндэслэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд зөвлөж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаанд:

1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын тооллогыг цаг хугацаанд нь чанартай явуулах, заавар аргачлалыг боловсронгуй болгох, үнэлгээ тогтоох итгэлцүүр гаргах, түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн ажлыг сайжруулах, музейг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх, ажилтнуудыг мэргэшүүлэх, арга зүйгээр хангах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж, улсын хэмжээний түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээнд оруулах;
3. Гаалийн ерөнхий газарт хураагдан хадгалагдаж байгаа эд зүйлсэд хамтарсан үзлэг, ангилал хийж, түүх соёлын дурсгалт зүйлд хамаарах эд, зүйлийг зохих байгууллагад шилжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
4. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 108 дугаар тогтоолоор хосгүй үнэт зүйлээр бүртгэгдсэн “Богд хаант Монгол улсын төрийн далбаа”-г олж, Үндэсний түүхийн музейд шилжүүлэн өгөх.

Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатарт:

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.5-д заасны дагуу гаальд хураагдан хадгалагдаж байгаа эд зүйлсэд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл урлагийн газартай хамтарсан үзлэг, ангилал хийж, түүх соёлын дурсгалт зүйлд хамаарах эд зүйлийг зохих байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авах;

Зөвлөмж

Үндэсний түүхийн музейн захирал А.Очирт:

1. Музейн нийт үзмэр, эд өлгийн зүйлийн лавлагааны материалын бүрдүүлэлтийг эрчимжүүлж, улсын бүртгэл-мэдээллийн санд бүрэн оруулах;
2. Музейн агуулга, төрөл, чиглэлийн дагуу музейн сан хөмрөгийг баяжуулах, иж бүрдүүлэх талаар хэтийн төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах;
3. Гэгээрлийн сайдын 1999 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Музейн үзмэрийг хадгалж, хамгаалах заавар”-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах;
4. Музейн барилга, үзмэрийн талбайг зориулалтын дагуу ашиглах, харуул хамгаалалтыг сайжруулж, хамгаалалтын тоног төхөөрөмжийг бүрэн ажиллуулах арга хэмжээ авах;
5. Хандив тусламжаар ирсэн үзмэр, техник тоног төхөөрөмжийг тухай бүр орлогод авч бүртгэлд тусган ариг гамтай ашиглаж байх, санхүү бүртгэлийн заавар, журмыг чанд мөрдөж ажиллах;
6. Тавигдсан акт, албан шаардлагыг хэрэгжүүлж, хариу мэдэгдэх.

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу

Тэргүүлэх аудитор О.Мэндбаяр

Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

№	Илэрсэн төлбөр, зөрчлийн дугаар	Хариуцах эзэн	Үүнээс	
			Төлбөр	Зөрчил
1.	акт № 01	Үндэсний түүхийн музейн дарга А.Очир нягтлан бодогч Ж.Наранчимэг	Түрээсийн төлбөрийн шимтгэлийн дутууг нөхөн төлүүлэх /1436.8 мянган төгрөг/	
2.	албан шаардлага № 01	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл урлагийн газрын дарга Н.Батмөнх		Засгийн газрын 2004 оны 108 дугаар тогтоолын дагуу “Богд хаант Монгол улсын төрийн далбаа”-г олж, музейд шилжүүлэх
3.	албан шаардлага № 02	Үндэсний түүхийн музейн дарга А.Очир нягтлан бодогч Ж.Наранчимэг		МУ-ын СЭЗ-ийн сайдын 182 дугаар тушаалаар батлагдсан “...мөнгөн кассын ажиллагааны түр журам”-ын заалт, музейн дүрмийг зөрчиж музейн зориулалтын байрыг хувь хүн, аж ахуйн байгууллагад олноор түрээслүүлсэн

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Үндэсний түүхийн музейн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Үндэсний түүхийн музейн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайланг УИХ-ын Нийгмийн бодлогын Байнгын хороо, БСШУ-ны яаманд танилцуулсугай.

Дөрөв. Үндэсний түүхийн музейн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2005 оны 10 дугаар сард Үндэсний аудитын газарт танилцуулахыг БСШУ-ны сайд П.Цагаан, Үндэсний түүхийн музейн дарга А.Очир нарт зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Хуулбар үнэн:

ТАМГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

С.ЛХАГВАСҮРЭН

Түрээсийн төлбөрийн шимтгэл
төлүүлэх тухай

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн тус музейн 2004 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийхэд гадны байгууллага, аж ахуйн нэгжид өөрийн байрны 316.5 кв/м талбайг гэрээний дагуу түрээслүүлж нийт 25190.2 мянган төгрөгийн орлого олж 3601.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5, Төрийн өмчийн хорооны 2001 оны 562 дугаар тогтоолын 2-т Түрээсийн орлогын 20 хувийг Төрийн өмчийн хорооны төсвийн дансанд төвлөрүүлж байх, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1.Түрээсийн төлбөрийн шимтгэлийн дутуу 1436.8 мянган төгрөгийг Төрийн өмчийн хорооны төрийн сангийн 900008005 дугаар дансанд 2005 оны 5 дүгээр сарын 15-ны дотор төлөхийг ҮТМ-н захирал А.Очир, нягтлан бодогч Ж.Наранчимэг нарт хариуцуулан акт тогтоов.

АКТ

Тогтоосон:
ҮАГ-ын шинжээч
Ц.Сугармаа

Танилцаж зөвшөөрсөн:
ҮТМ-н захирал
А.Очир
Ня-бо
Ж.Наранчимэг

ҮНДЭСНИЙ ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗАХИРАЛ
А.ОЧИР ТАНАА

Илэрсэн зөрчлийг арилгуулах тухай

Улсын Их хурлын Нийгмийн бодлогын Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Үндэсний түүхийн музейн 2004 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Төрийн өмчийн хорооны 2002 оны 562 дугаар тогтоолоор төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлж болох боловч музейн дүрэмд /Музей нь монгол нутаг дах хүний амьдралын түүх, соёл, урлаг, ёс заншил, байгаль орчны тухай бодит баримтат материалуудыг цуглуулан хадгалж, судлан шинжлэх, дэглэн үзүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагааг байнга явуулах үүрэг бүхий, ашгийн төлөө бус, соёлын байгууллага, музейн байрыг зөвхөн музейн үйл ажиллагаанд ашиглана/ заасан байдаг тул танай байгууллага 316.8 кв/м талбайг түрээсэлж орлого олж байна.

Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 182 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны түр журмын 5 дугаар зүйлийн 1,2,3,4 дэх зүйлийн заалтыг зөрчин, бэлэн мөнгөний кассын өрөөнд үйлчлүүлэгчдийн хувцасны өлгүүр, цүнх сав тавьдаг шүүгээ байрлуулсан, Монгол Улсын гэгээрлийн сайдын 1997 оны 330 дугаар тушаалаар батлагдсан “ Улс, аймгийн чанартай музейн дүрэм”-ийн 2.9, 2.10, 7.1, 8.1-д /Үзэгчдэд зориулан музейн байр, танхимын цэвэр тохилог орчин бүрдүүлэх, сан хөмрөгөө түшиглэн үзэсгэлэн тогтмол зохион байгуулж, үзэсгэлэнгийн байнгын танхим ажиллуулах, музейн зориулалтын байрыг зөвхөн музейн үйл ажиллагаанд ашиглана, музейн байранд бэлэг дурсгалын дэлгүүр ажиллуулж болно/ заасан заалтыг зөрчсөн зөрчлүүд илэрлээ.

Иймд дээрх зөрчил дутагдлыг арилгуулахаар Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу албан шаардлагыг хүргүүлж байна.

Дээрх зөрчлийг 2005 оны 10 дугаар сарын 1-ны дотор барагдуулж манайд хариу ирүүлнэ үү.

Шаадлагыг бичсэн:
Шинжээч

Ц.Сугармаа

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны
Соёл урлагийн газрын дарга Н.Батмөнх танаа

Илэрсэн зөрчлийг арилгуулах тухай

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу МУ-ын Засгийн газрын 2004 оны 108 дугаар тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл болох 19 дүгээр зууны үед бүтээгдсэн шар, улаан өнгийн торгоор соёмбо хатган урласан 2.82 x 1.05 см хэмжээтэй “Богд хаант Монгол улсын төрийн далбаа” Үндэсний түүхийн музейн сан хөмрөгт байхгүй байгаа зөрчил илэрсэн тул дээрх тогтоолын заалтыг хэрэгжүүлэх үүднээс Богд хаант Монгол улсын төрийн далбааг олж, Үндэсний түүхийн музейд шилжүүлэх нь зүйтэй байна.

Иймд дээрх зөрчил дутагдлыг арилгуулахаар Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу албан шаардлагыг хүргүүлж байна.

Зөрчлийг 2005 оны 7 дугаар сарын 1-ны дотор барагдуулж хариуг ирүүлнэ үү.

Албан шаардлагыг бичсэн:
Шинжээч

Ц.Сугармаа